

## АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

### А. ТАНИЛЦУУЛГА

<b>1. Байгууллагын нэр:</b> _____ аймаг дахь төрийн аудитын газар	<b>2. Нэгжийн нэр:</b> Аудитын алба	
<b>3. Ажлын байрны нэр:</b> _____ аймаг дахь төрийн аудитын газрын Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер	<b>3.1. Албан тушаалын ангилал:</b> Төрийн аудитын зөвлөх түшээ	<b>3.2. Албан тушаалын зэрэглэл:</b> AA-5
<b>4. Ажлын байрыг шууд харьяалан удирдагдах албан тушаалын нэр:</b>  Газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор	<b>4.1. Албан тушаалын ангилал:</b>  Төрийн аудитын итгэмжит түшээ	<b>4.2. Албан тушаалын зэрэглэл:</b>  AA-3

### Б. ЧИГ ҮҮРЭГ

<b>1. Ажлын байрны зорилго</b>	Төрийн аудитын тухай хууль, тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хэмжээнд тухайн орон нутагт хийх аудитыг мэргэжлийн удирдлагаар хангах, хянан удирдах, чанарын хяналт тавих, тайлагнах.	
<b>2. Ажлын байрны үндсэн зорилт</b>	<b>2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт</b>	
2.1. Тухайн орон нутгийн төсвийн бүх шатны захирагч нарын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон, Төрийн аудитын байгууллагын аудитын журмуудад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргах, аудитыг хянан удирдаж, чанарын хяналт хийх, санхүүгийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан гарын авлага, дүрэм, журмуудыг аудитор, ахлах аудитор болон аудитын багууд мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, арга зүйгээр хангах.	<ul style="list-style-type: none"> <li>Төсвийн тухай хууль болон төрийн аудитын тухай хуулийн заалтууд хугацаандаа, чанартай бүрэн хэрэгжсэн байх.</li> <li>Аудитын олон улсын стандартад нийцсэн байх</li> <li>Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах.</li> </ul>	
2.2. Тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллага төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвигч хямгагч, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж	<ul style="list-style-type: none"> <li>Аудит Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөнд заасан хугацаанд чанартай бүрэн хэрэгжсэн байх.</li> </ul>	

<p>байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргах, аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавих, гүйцэтгэлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гарын авлага, дүрэм, журмыг аудитор, ахлах аудитор болон аудитын багууд мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, арга зүйгээр хангах.</p>	
<p>2.3. Тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллага үйл ажиллагаандаа хууль, тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдалд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт хийх, нийцлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гарын авлага, дүрэм, журмуудыг аудитор, ахлах аудитор болон аудитын багууд мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, арга зүйгээр хангах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн хяналт шалгалтын стандарт гүйцэтгэлийн шалгалтын журам, гарын авлагын дагуу хийсэн байх.</li> <li>• Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллах.</li> </ul>
<p>2.4. Монгол Улсын Хууль тогтоомж болон Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажилд хяналт тавьж, аудитын багийн гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх талаар арга зүйгээр хангах, хянан удирдах.</p>	<p>Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал шийдвэрийг хэрэгжүүлэх.</p>
<p><b>3.Ажлын байрны гол үйл ажиллагаа</b></p>	
<p style="text-align: center;"><b><u>Ажлын байрны 1 дүгээр зорилтын хүрээнд:</u></b></p> <p>1.1. Орон нутгийн төсвийн бүх шатны захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналтыг хариуцна.</p> <p>1.2. Эрсдэлийн аудитын стандарт, арга зүйг мөрдөж ажиллах, нийцлийн болон эрсдэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах ажлыг хянан удирдаж, үр дүнд хяналт тавина.</p> <p>1.3. Орон нутагт хэрэгжиж байгаа Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаанд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>1.4. Үндэсний аудитын газраас баталсан нэгдсэн төлөвлөгөө, өгсөн чиглэлийг үндэслэн орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн санхүүгийн тайланд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт хийнэ.</p> <p>1.5. Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавьж арга зүйгээр хангана.</p> <p>1.6. Төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүгийн аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</p>	<p style="text-align: center;"><b>3.1. хувиар</b></p> <p style="text-align: center;">30</p>

<p>1.7. Зарим байгууллагын санхүүгийн тайланд хувийн хэвшлийн аудитын компаниудаар гэрээгээр гүйцэтгүүлж буй аудитад чанарын хяналт тавина.</p> <p>1.8. Санхүүгийн аудитын чиглэлээр аймаг, нийслэл дэх хувийн хэвшлийн аудитын компаниудад арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлнэ.</p> <p>1.9. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах, үр дүнг мэдээлнэ.</p> <p>1.10. Санхүүгийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гарын авлага, дүрэм, журмыг аудитор, ахлах аудитор болон аудитын баг мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, зааварчилгаа өгнө.</p>	
<p style="text-align: center;"><b><u>Ажлын байрны 2 дугаар зорилтын хүрээнд:</u></b></p> <p>2.1. Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, төсвийн захиран зарцуулалтад хийх гүйцэтгэлийн аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>2.2. Үндэсний аудитын газраас баталсан нэгдсэн төлөвлөгөө, өгсөн чиглэлийг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, зарцуулалтад хийх гүйцэтгэлийн аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>2.3. Орон нутагт хэрэгжиж байгаа Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>2.4. Орон нутгийн /аймаг, сум, дүүрэг/ төсвийн гүйцэтгэлийн тайланд хийх аудитыг хянан удирдаж, чанарын хяналт хийнэ.</p> <p>2.5. Орон нутгийн төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн төсөл болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал, төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагууд хангагдсан эсэх талаар дүгнэлт боловсруулна.</p> <p>2.6. Тухайн орон нутгийн төрийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн нөөцийг хэрхэн арвич хямгач, үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй ашиглаж байгааг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гаргах ажлыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>2.7. Гүйцэтгэлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гарын авлага, дүрэм, журмыг аудитор, ахлах аудитор болон аудитын баг мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, зааварчилгаа өгнө.</p>	30
<p style="text-align: center;"><b><u>Ажлын байрны 3 дугаар зорилтын хүрээнд:</u></b></p> <p>3.1. Орон нутгийн хэмжээнд хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт, Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрүүдийн хэрэгжилтийг шалгах аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>3.2. Төрийн болон төрийн өмчит байгууллагуудад хийх нийцлийн аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p>	

<p>3.3. Нийцлийн аудитын бодлого, стандарт, арга зүйг мөрдөж ажиллахад хяналт хийнэ.</p> <p>3.4. Эрх бүхий байгууллагын захиалгаар болон шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тодорхой асуудлаар хийх нийцлийн аудитыг хянан удирдаж, чанарын хяналт тавина.</p> <p>3.5. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулах ажлыг хянан удирдаж, үр дүнг мэдээлнэ.</p> <p>3.6. Нийцлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, давтан шалгах үе шатанд мөрдөх аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, гарын авлага, дүрэм, журмыг аудитор, ахлах аудитор болон аудитын баг мөрдөж ажилласан эсэхийг шалгаж, хянан удирдаж, зааварчилгаа өгнө.</p>	20
<p style="text-align: center;"><b><u>Ажлын байрны 4 дүгээр зорилтын хүрээнд:</u></b></p> <p>4.1. Стандарт, арга зүйг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт гаргах, аудит хийх байгууллага, үйл ажиллагааны талаар судалгаа хийх ажлыг тэргүүлэх аудиторын удирдлаган дор зохион байгуулна.</p> <p>4.2. Аудитын үр дүнг холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлэх ажлыг бэлтгэж аймаг, нийслэлийн тэргүүлэх аудиторт танилцуулна.</p> <p>4.3. Аудитын газрын болон аудитын үйл ажиллагаа, зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт, үр өгөөжийн тооцоо, бүх төрлийн мэдээ, тайлан, чанарт хяналт тавина.</p> <p>4.4. Аудитын багийн ажилтнуудын ажлын зохицуулалтыг жигд тэгш ачаалалтай ажиллуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах.</p> <p>4.5. Мэдээлэл, техник технологийн дэвшлийг ашиглах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, мэдээллийг бэлтгэх үйл ажиллагаанд хяналт хийнэ.</p> <p>4.6. Газрын дарга, тэргүүлэх аудиторын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, гаргасан тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих.</p>	20

### **В.ТАВИГДАХ ШААРДЛАГА**


1.Ажлын байранд тавигдах шаардлага	1.1.Ерөнхий шаардлага	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
		<b>Боловсрол</b>	Дээд боловсролын бакалавр болон түүнээс дээш	Магистр зэрэгтэй байх
		<b>Мэргэжил</b>	Эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, төрийн удирдлага.	
		<b>Мэргэшил</b>	Эдийн засаг, санхүү, хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байх.	Мэргэшсэн нягтлан бодогч
		<b>Туршлага</b>	Төрийн албанд болон мэргэжлээрээ 8-аас доошгүй жил, удирдах албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
		<b>Ур чадвар</b>	-Монгол хэл бичгийн болон албан хэрэг хөтлөлтийн ур чадвар эзэмшсэн байх.	

			-Баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ур чадвартай байх. -Хууль эрх зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн өргөн хэрэглээний программыг бүрэн эзэмшсэн байх. -Удирдан зохион байгуулах чадвартай байх. - Харилцааны соёлтой байх.
	<b>Тусгай шаардлага</b>		<ul style="list-style-type: none"> <li>• Багаар ажиллах чадвартай байх.</li> <li>• НҮБ-д хүлээн зөвшөөрөгдсөн аль нэг гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх.</li> <li>• Төр, болон байгууллага, иргэдийн нууцыг хадгалах.</li> <li>• Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчилгүй байх.</li> </ul>

### Г.ХҮЧИН ЗҮЙЛС

<b>1.Ажлын байрны харилцах субъект</b>		
<b>1.1.Байгууллагын дотор талд байгаа</b>	<b>1.2.Байгууллагын гадна талд байгаа</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Тэргүүлэх аудитор, ахлах аудитор, аудиторууд</li> <li>- Газрын бусад ажилтнууд</li> </ul>	<b>Шууд харилцах байгууллага:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний аудитын газар</li> <li>- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</li> </ul> <b>Шууд бус харилцах байгууллага:</b> <ul style="list-style-type: none"> <li>- ТББ, иргэд,</li> <li>- Орон нутгийн төсвийн байгууллагууд</li> </ul>	
<b>2.Албан тушаал эрхлэгчийн хүлээх хариуцлага</b>	Ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргээ хангалтгүй биелүүлсэн, Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг зөрчсөн, бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.	
<b>3.Ажлын байрны нөөц, хэрэглэл</b>	<b>3.1.Санхүүгийн</b>	АА-5 ангилал, зэрэглэлийн цалин, нэмэгдэл, урамшуулал
	<b>3.2.Материалын</b>	Албан үүргээ гүйцэтгэхэд шаардагдах: <ul style="list-style-type: none"> <li>- Албан ерөөний тавилга</li> <li>- Компьютер болон шаардлагатай бусад техник хэрэгсэл, Бичиг хэргийн материал</li> </ul>
	<b>3.3.Бусад</b>	Албан ажлын унаа хэрэглэх
<b>4.Ажлын байрны нөхцөл</b>	<b>4.2.Онцгой нөхцөл</b>	Албан ажлын нууц хадгалах, шаардлагатай үед илүү цагаар ажиллана

Д.БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулсан: Ажлын хэсгийн ахлагч	Ажлын байрны тодорхойлолт баталсан: Эрх бүхий албан тушаалтан
Албан тушаалын нэр: Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга	Албан тушаалын нэр: Монгол Улсын Ерөнхий аудитор
 ..... Ц.ГАНБОЛД 2017 оны 05 сарын 22-ны өдөр	 ..... Д.ХҮРЭЛБААТАР 2017 оны 05 сарын 22-ны өдөр